

**МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
ДААТГАЛЫН ГАЗАР**

**ДААТГАЛЫН САЛБАРЫН 2013 ОНЫ 2 ДУГААР  
УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАНИЛЦУУЛГА**

**ТАНИЛЦСАН:**

ХОРООНЫ ДАРГА	Д. БАЯРСАЙХАН
ХОРООНЫ ГИШҮҮН	Г. ХЭРЛЭН
ХОРООНЫ ГИШҮҮН	Б. ДААЖАМБА
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА	Х. БУМ-ЭРДЭНЭ

**ХЯНАСАН:**

ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА	С. ГАНБОЛД
ДААТГАЛЫН ГАЗРЫН БТХ-ИЙН ДАРГА	П. ЦЭРЭНДЭЖИД

**БОЛОВСРУУЛСАН:**

ДААТГАЛЫН ГАЗРЫН ХЯНАН ШАЛГАГЧ	Э. ЭРДЭНЭТУЯА
--------------------------------	---------------

## **АГУУЛГА**

### **1. ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ**

- 1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
- 1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ
- 1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- 1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- 1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- 1.6 ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- 1.7 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА
- 1.8 ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- 1.9 ДАВХАР ДААТГАЛ

### **2. ЕРДИЙН ДААТГАЛ**

- 2.1 ЕРДИЙН ДААТГАЛ
- 2.2 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ
- 2.3 ЕРДИЙН ДААТГАЛЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ
- 2.4 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО
- 2.5 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР
- 2.6 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН
- 2.7 ЕРДИЙН ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА
- 2.8 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН
- 2.9 ЕРДИЙН ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ

### **3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ**

- 3.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ
- 3.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨР
- 3.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГ, НӨӨЦ САН

### **4. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ**

- 4.1 ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ
- 4.2 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ

## **ДҮГНЭЛТ**

## ДААТГАЛЫН САЛБАРЫН 2013 ОНЫ 2 УЛИРЛЫН САНХҮҮ, ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН

### 1. ДААТГАЛЫН САЛБАРЫН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

#### 1.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2013 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын зах зээл дээр ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 17 компани, 240 даатгалын салбар, 3227 даатгалын төлөөлөгч, 20 даатгалын зуучлагч компани, 11 даатгалын хохирол үнэлэгч компани, 15 актуарч, нийт 3290 тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагаагаа явуулж байна.


Хүснэгт 1

#### Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

Он	2009-II	2010-II	2011-II	2012-II	2013-II
Даатгагч	17	16	17	18	17
Даатгалын компанийн салбар	130	134	149	191	240
Даатгалын компанийн төлөөлөгчийн газар					4
Даатгалын төлөөлөгч	1233	2006	1992	2180	3227
Даатгалын зуучлагч	4	8	9	13	20
Даатгалын хохирол үнэлэгч		6	7	9	11
Даатгалын актуарч		10	12	15	15
Бүгд	1384	2180	2186	2426	3290

Даатгалын зах зээл дэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо нь энэ оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 1.1 дахин өссөн байна.

Тайлант хугацаанд 1 компанийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 3 даатгалын зуучлагч компани, 2 даатгалын хохирол үнэлэгч компани тус тус нэмж мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна. [График 1](#)




Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд, хувь хүмүүсийн тоо сүүлийн 5 жилийн байдлаар 2.6 дахин өссөн байна.

## 1.2 ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨ

2013 оны 2 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 17 компанийн хөрөнгийн нийт хэмжээ 113.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.6 тэрбум төгрөг буюу 1.1 дахин өссөн байна. Сүүлийн 5 жилийн байдлаар тайлант үеийн мөн үеийн байдалтай харьцуулахад 3.0 дахин нэмэгдсэн нь даатгалын компаниудын дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх Хорооны бодлоготой холбоотой юм.

График 2



Даатгалын салбарын нийт эргэлтийн хөрөнгө 2012 оны 2 дугаар улиралд 80.6 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 82.6 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 17.0 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 17.3 хувийг эзэлж байсан бол тайлант оны мөн үед эргэлтийн хөрөнгө 96.3 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 85.0 хувь, эргэлтийн бус хөрөнгө 17.0 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 15.0 хувийг эзэлж байна.

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө өмнөх оны мөн үеийнхээс 2.44 дахин өссөн нь дүрмийн сангийн доод хэмжээг нэмсэнтэй холбоотой юм. Харин нийт хөрөнгөд эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувийн жин өмнөх оны мөн үеэс буурч, эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувийн жин нэмэгдсэн байна. Үүнд богино хугацаат хөрөнгө оруулалт, банкны хадгаламж, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт нөлөөлсөн. [Хүснэгт 2](#)

### Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө

сая төгрөгөөр

Үзүүлэлтүүд	2012.06.30		2013.06.30		Өсөлт/ бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт
Эргэлтийн хөрөнгө	80,673.20	82.61	96,297.20	85.06	15,624.00	2.44
Эргэлтийн бус						

хөрөнгө	16,980.20	17.39	16,918.30	14.94	(61.90)	(2.44)
Нийт хөрөнгө	97,653.40	100.00	113,215.50	100.00	15,562.10	(0.00)

2013 оны 2 дугаар улирлын байдлаар эргэлтийн хөрөнгийн 59.8 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 23.3 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 14.34 хувийг дансны авлага, үлдэх 2.56 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байсан байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад богино хугацаат хөрөнгө оруулалт 4.6 пунктээр, дансны авлага 0.14 пунктээр, бусад эргэлтийн хөрөнгө 0.22 пунктээр буурч, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 4.99 пунктээр өссөн байна.

Эргэлтийн хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеийнхээс 15.6 тэрбум төгрөгөөр өссөн байгаа бөгөөд үүнд Хорооны 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 355 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” шийдвэр хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой байна. [Хүснэгт 3](#)

**Эргэлтийн хөрөнгө /сая төгрөгөөр/**

Үзүүлэлтүүд	2012.06.30		2013.06.30		Өөрчлөлт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө</b>	44,219.70	54.81	57,588.20	59.80	13,368.50	4.99
<b>Богино хугацаат хөрөнгө оруулалт</b>	22,531.80	27.93	22,433.20	23.30	(98.60)	(4.63)
<b>Дансны авлага</b>	11,680.20	14.48	13,810.50	14.34	2,130.30	(0.14)
<b>Бусад эргэлтийн хөрөнгө</b>	2,241.50	2.78	2,465.30	2.56	223.80	(0.22)
Эргэлтийн хөрөнгийн дүн	<b>80,673.20</b>	<b>100.00</b>	<b>96,297.20</b>	<b>100.00</b>	<b>15,624.00</b>	<b>0.00</b>

2013 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь харуулахад “Хаан даатгал” ХХК хамгийн бага буюу 2.7 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр зах зээлийн нийт хөрөнгийн 2.4 хувийг эзэлж байна.

Даатгалын зах зээл дээрх нийт хөрөнгийн 20.2 хувийг “Монгол даатгал” ХХК дангаараа бүрдүүлж байна. [Хүснэгт 4](#)

**Нийт хөрөнгийн хэмжээ**

*/2013 оны хагас жилийн байдлаар, сая төгрөгөөр/*

	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	7,343.4	6.5
2	Бодь даатгал ХХК	12,424.4	11.0
3	Ган зам даатгал ХХК	2,819.2	2.5
4	Мандал женерал даатгал ХХК	7,681.8	6.8

5	Миг даатгал ХХК	7,551.2	6.7
6	Монгол даатгал ХХК	22,906.9	20.2
7	Гэр даатгал ХХК	2,731.9	2.4
8	Моннис даатгал ХХК	3,987.6	3.5
9	Мөнх даатгал ХХК	2,990.1	2.6
10	Номин даатгал ХХК	6,086.1	5.4
11	Нэйшнл лайф даатгал ХХК	4,842.1	4.3
12	Практикал даатгал ХХК	7,479.2	6.6
13	Тэнгэр даатгал ХХК	8,258.0	7.3
14	Соёмбо даатгал ХХК	6,231.8	5.5
15	Монре даатгал ХХК	3,891.7	3.4
16	Хаан даатгал ХХК	2,694.1	2.4
17	УБ хотын даатгал ХХК	3,296.9	2.9
	<b>Дүн</b>	<b>113,216.4</b>	<b>100.0</b>

### 1.3 ДААТГАГЧИЙН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ

Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 3 жилээр хагас жилийн байдлаар харьцуулж харахад дараах байдалтай байна. [График-3](#)



Даатгалын нөөц сан нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчид 2011 оны 2 дугаар улиралд 47.0 хувийг эзэлж байсан бол 2012 оны мөн үед 47.1 хувь, тайлант үед 47.0 хувийг эзэлж байгаа нь сүүлийн 3 жилийн нөөцийн сангийн нийт хөрөнгөнд эзлэх хувь тогтвортой байх хандлага ажиглагдаж байна.

Эзэмшигчдийн өмчийн нийт хөрөнгийн өр төлбөрт эзлэх хувийн жин 2011 оны мөн үеэс 5.1 хувь байснаа 2012 оны мөн үед 5.9 хувь, тайлант үед 6.0 хувь болж 0.1 пунктээр өссөн байна.

### 1.4 ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2013 оны 2 дугаар улиралд 42,416.5 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.014 дахин өссөн байна. Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн даатгагчид нийт 41932.6 сая төгрөг, урт хугацааны даатгагч 483.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Ердийн даатгалын орлого өмнөх оны мөн үеийнхээс 410.3 сая төгрөгөөр, урт хугацааны даатгалын орлого 141.0 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээ нь 12549.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 5

Даатгалын нийт орлого

сая төгрөгөөр

Даатгалын хэлбэр	2012.	2013.06.30		Өсөлт бууралт
	06.30	Даатгалын (сая.төг)	нийт орлого	
1.1 Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	3,101.90		3,708 .10	1.20
1.2 Хөрөнгийн даатгал	10,273.90		10,05 4.20	0.98
1.3 Автотээврийн хэрэгслийн даатгал	8,650.00		8,654 .80	1.00
1.4 Ачааны даатгал	643.40		911.8 0	1.42
1.5 Барилга угсралтын даатгал	684.70		524.4 0	0.77
1.6 Газар тариалангийн даатгал	0.00		0.00	0.00
1.7 Мал амьтдын даатгал	0.00		0.00	0.00
1.8 Агаарын хөлгийн даатгал	4,301.90		3,777 .90	0.88
1.9 Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	9,293.00		3,229 .50	0.35
1.10 Хариуцлагын даатгал	3,692.80		4,272 .70	1.16
1.11 Санхүүгийн даатгал	880.60		1,163 .30	1.32
1.12 Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал			4,844 .00	0.00
1.13 Зээлийн даатгал			708.5 0	0.00
1.14 Итгэлцлийн даатгал			-	0.00
1.15 Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал			-	0.00
1.16 Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал			-	0.00
1.17 Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал			83.30	0.00
2.1 Хугацаат амьдралын даатгал	178.20		206.6 0	1.16
2.2 Насан туршийн даатгал				0.00

2.3. Хуримтлалын даатгал	63.50	60.90	0.96
2.4 Тэтгэврийн даатгал	17.90	26.20	1.46
2.5. Эрүүл мэндийн даатгал	83.30	190.20	2.28
		0	
2.6 Аннуити даатгал	0.00	0.00	0.00
Дүн	41,865.10	42,416.40	1.01

### 1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2013 оны 2 дугаар улиралд нийт 11,781.2 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон байна. Тайлант хугацаанд өмнөх оны мөн үеийнхээс гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1.14 хувиар, хөрөнгийн даатгал 2.59 хувиар, автотээврийн хэрэгслийн даатгал 1.10 хувиар, ачааны даатгал 1.39 хувиар, агаарын хөлгийн даатгал 0.62 хувиар, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 0.94 хувиар, хариуцлагын даатгал 1.36 хувиар, санхүүгийн даатгал 0.41 хувиар, хугацаат амьдралын даатгал 1.01 хувиар, хуримтлалын даатгал 1.15 хувиар, тэтгэврийн даатгал 0.74 хувиар, эрүүл мэндийн даатгал 1.61 хувиар, тус тус нэмэгдсэн байна. **Хүснэгт 6**

#### Даатгалын нийт нөхөн төлбөр

сая төгрөгөөр

Даатгалын хэлбэр	2012.06.30	2013.06.30	Өсөлт бууралт
	Даатгалын төлбөр(сая.төг)	нийт нөхөн	
1.1 Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	853.30	974.50	1.14
1.2 Хөрөнгийн даатгал	502.00	1,299.00	2.59
1.3 Автотээврийн хэрэгслийн даатгал	3,048.90	3,353.60	1.10
1.4 Ачааны даатгал	90.70	126.30	1.39
1.5 Барилга угсралтын даатгал		25.30	0
1.6 Газар тариалангийн даатгал			0.00
1.7 Мал амьтдын даатгал			0.00
1.8 Агаарын хөлгийн даатгал	8.70	5.40	0.62
1.9 Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	1,195.80	1,121.70	0.94
1.10 Хариуцлагын даатгал	118.20	160.20	1.36
1.11 Санхүүгийн даатгал	618.20	253.80	0.41
1.12 Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал		3,650.70	0.00
1.13 Зээлийн даатгал		689.40	0.00
1.14 Итгэлцлийн даатгал			0.00




1.15 Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал			0.00
1.16 Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал			0.00
1.17 Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал			0.00
2.1. Хугацаат амьдралын даатгал	23.80	24.00	1.01
2.2 Насан туршийн даатгал			0.00
2.3. Хуримтлалын даатгал	32.00	36.80	1.15
2.4 Тэтгэврийн даатгал	3.50	2.60	0.74
2.5. Эрүүл мэндийн даатгал	36.00	57.90	1.61
2.6 Аннуити даатгал			0.00
Дүн	<b>6,531.10</b>	<b>11,781.20</b>	1.80

Тайлант оны мөн үеийн даатгагчийн нөхөн төлбөр 11.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 5.2 тэрбум төгрөгөөр өссөн буюу 1.8 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй харагдаж байна.

### 1.5 ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН

2013 оны 2 дугаар улиралд даатгалын нөхөн олговрын түвшин даатгалын салбарын дүнгээр 42.0 хувь болж өмнөх жилийн мөн үеийнхээс 12.3 пунктээр өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж түвшин 34.0 хувьтай байна. **График 4**



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын нөхөн олговрын түвшингээр харьцуулахад 2013 оны 2 дугаар улирлын байдлаар “Монгол даатгал” ХХК, “Соёмбо даатгал” ХХК-иуд 53.0 хувь буюу хамгийн өндөр хувьтай байна. **Хүснэгт 7**

### Нөхөн олговрын түвшин

хувиар

№	Даатгалын компаниудын нэрс	2012.06.30	2013.06.30	Өсөлт бууралт
---	----------------------------	------------	------------	---------------

				пунктээр
1	Ард даатгал ХХК	29	33.4	4.4
2	Бодь даатгал ХХК	29.5	34.1	4.6
3	Ган зам даатгал ХХК	4	9.1	5.1
4	Мандал женерал даатгал ХХК	5	31.2	26.2
5	Жонон даатгал ХХК	0		0.0
6	МИГ даатгал ХХК	33.6	48.8	15.2
7	Монгол даатгал ХХК	38.5	53.0	14.5
8	Гэр даатгал ХХК	3.9	32.3	28.4
9	Моннис даатгал ХХК	15.6	6.4	-9.2
10	Мөнх даатгал ХХК	9.6	27.9	18.3
11	Номин даатгал ХХК	31.6	50.6	19.0
12	Нэйшнл лайф даатгал ХХК	27.8	26.7	-1.1
13	Практикал даатгал ХХК	22.8	44.3	21.5
14	Тэнгэр даатгал ХХК	25.6	36.9	11.3
15	Соёмбо даатгал ХХК	36.8	53.0	16.2
16	Монре даатгал ХХК	19.7	50.3	30.6
17	Хаан даатгал ХХК	0	21.3	21.3
18	УБ хотын даатгал ХХК	13.4	8.3	-5.1
	ДҮН	30.1	42.3	12.2

Даатгалын компаниудаас даатгуулагчдад олгосон даатгалын нөхөн олговрын түвшинг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад “Бодь даатгал” ХХК 4.6 пунктээр, “Миг даатгал” ХХК 15.2 пунктээр, “Ард даатгал” ХХК 4.4 пунктээр, “Ганзам даатгал” ХХК 5.1 пунктээр, “Гэр даатгал” ХХК 28.4 пунктээр, “Мөнх даатгал” ХХК 18.3 пунктээр, “Номин даатгал” ХХК 19.0 пунктээр, “Практикал даатгал” ХХК 21.5 пунктээр, “Тэнгэр даатгал” ХХК 11.3 пунктээр, “Соёмбо даатгал” ХХК 16.2 пунктээр, “Монре даатгал” ХХК 30.6 пунктээр тус тус өсч, “Нэйшнл лайф даатгал” ХХК 1.1 пунктээр, Моннис даатгал” ХХК 9.2 пунктээр “УБ хотын даатгал” ХХК 5.1 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

## 1.6 ДААТГАГЧИЙН АШИГТ АЖИЛЛАГАА

2013 оны 2 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 3494.1 сая төгрөг болсон байна. Өмнөх жилийн мөн үеийнхээс 199.2 сая төгрөгөөр нэмэгдсэн буюу 1.06 дахин өссөн байна. [Хүснэгт 8](#)

### Даатгалын цэвэр ашиг, алдагдал

сая төгрөгөөр

№	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	1,853.0	53.0
2	Бодь даатгал ХХК	98.3	2.8
3	Ган зам даатгал ХХК	254.7	7.3
4	Мандал женерал даатгал ХХК	103.7	3.0
5	МИГ даатгал ХХК	94.7	2.7
6	Монгол даатгал ХХК	637.3	18.2
7	Гэр даатгал ХХК	50.1	1.4

8	Моннис даатгал ХХК	185.1	5.3
9	Мөнх даатгал ХХК	11.0	0.3
10	Номин даатгал ХХК	42.3	1.2
11	Нэйшнл лайф даатгал ХХК	(41.9)	-1.2
12	Практикал даатгал ХХК	143.6	4.1
13	Тэнгэр даатгал ХХК	449.3	12.9
14	Соёмбо даатгал ХХК	(89.6)	-2.6
15	Монре даатгал ХХК	41.3	1.2
16	Хаан даатгал ХХК	(413.0)	(11.82)
17	УБ хотын даатгал ХХК	74.2	2.1
	<b>ДҮН</b>	<b>3,494.1</b>	<b>100.0</b>

Тайлант үеийн “Нэйшнл лайф даатгал” ХХК 41.9 сая төгрөг, “Соёмбо даатгал” ХХК 89.6 сая төгрөг, “Хаан даатгал” ХХК 413.0 сая төгрөгийн тус тус алдагдалтай ажилласан ба энэ нь нийт даатгалын салбарын хэмжээний тайлант үеийн цэвэр ашгийг бууруулахад нөлөөлсөн байна. [График 5](#)




Даатгалын компаниудын хуримтлагдсан ашгийг сүүлийн 3 жилийн байдлаарх мөн үеийн байдалтай харьцуулахад 1.1 дахин буурсан байна.

### 1.7 ДААТГАЛЫН НӨӨЦ САН

Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 3 жилийн эхний хагас байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч ирсэн байна. 2011 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын нөөц ... тэрбум, 2012 оны мөн үед 46.0 тэрбум байсан бол тайлант оны мөн үед 53.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 1.16 дахин өссөн байна. [График 6](#)

### Даатгалын нөөц сан



### 1.8 ДАВХАР ДААТГАЛ

2013 оны 2 дугаар улиралд даатгалын компаниуд гадаадын давхар даатгалын компаниудад их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж 11.0 тэрбум төгрөгийн хураамж төлсөн ч өнгөрөгч оны мөн үетэй харьцуулахад 213.7 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна. [График 7](#)



### Хүснэгт 9

#### Давхар даатгалын хураамж

(сая төгрөгөөр)

№	Компанийн нэр	2012-II		2013-II		Өөрчлөлт	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь

1	Ард даатгал ХХК	986.8	8.77	661.9	6.00	-324.9	(2.77)
2	Бодь даатгал ХХК	3914.4	34.80	1746.1	15.82	-2168.3	(18.97)
3	Тэнгэр даатгал ХХК	188.5	1.68	747.2	6.77	558.7	5.09
4	Практикал даатгал ХХК	68.8	0.61	87.8	0.80	19	0.18
5	Миг даатгал ХХК	1215.6	10.81	1117.2	10.12	-98.4	(0.68)
6	Монгол даатгал ХХК	3420.2	30.40	4653.6	42.17	1233.4	11.76
7	Номин даатгал ХХК	6.9	0.06	35.2	0.32	28.3	0.26
8	Нэйшнл лайф даатгал ХХК		-	29.6	0.27	29.6	0.27
9	Монре даатгал ХХК	63.6	0.57	54.7	0.50	-8.9	(0.07)
10	Соёмбо даатгал ХХК	28.2	0.25	300.6	2.72	272.4	2.47
11	Ган зам даатгал ХХК	170.5	1.52		-	-170.5	(1.52)
12	Мандал женерал даатгал ХХК	334.2	2.97	560.4	5.08	226.2	
13	Моннис даатгал ХХК	852.1	7.57	1041.8	9.44	189.7	1.87
	<b>ДҮН</b>	<b>11,249.80</b>	<b>00</b>	<b>11,036.10</b>	<b>100</b>	<b>-213.7</b>	<b>2.10716</b>

Гадаадын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн хэмжээг 2012 оны мөн үеийнхтэй харьцуулахад “Ард даатгал” ХХК 324.9 сая төгрөгөөр, “Бодь даатгал” ХХК 2168.3 сая төгрөгөөр, “Миг даатгал” ХХК 98.4 сая төгрөгөөр “Ган зам даатгал” ХХК 170.5 сая төгрөгөөр, “Монре даатгал” ХХК 8.9 сая төгрөгөөр тус тус буурч бусад даатгагчийн хувьд нэмэгдсэн байна.

2013 онд “Ард даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК-иудын өөрсдийн эрсдэлээ гадаадын давхар даатгагчид даатгуулсан давхар даатгалын хураамжийн бууралт нь салбарын хэмжээний дүнг бууруулахад нөлөөлсөн байна.

## 2. ЕРДИЙН ДААТГАЛ

### 2.1 ЕРДИЙН ДААТГАЛ

2013 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 16 ердийн даатгагч үйл ажиллагаа явуулж байна. Ердийн даатгалын компанийн салбар 240 болсон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 1.2 хувиар нэмэгдсэн байна.

### 2.2 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ

Тайлант үеийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 16 даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 108.4 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 14.4 тэрбум төгрөгөөр буюу 1.15 дахин өссөн байна.

### 2.3 ЕРДИЙН ДААТГАЛЫН ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Эзэмшигчийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувийн жин 2009 оноос тогтвортой өссөн байна. [Хүснэгт 10](#)

#### Эзэмшигчдийн өмч

Санхүүгийн үзүүлэлт	2012.06.30		2013.06.30		/сая төгрөгөөр/ Өсөлт бууралт	
	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь
Эзэмшигчдийн өмч	34,653.10	81.00	46,826.50	88.10	12,173.40	7.10
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	8,208.60	19.00	6,348.80	12.00	(1,859.80)	(7.00)
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>42,861.70</b>	<b>100.00</b>	<b>53,175.30</b>	<b>100.10</b>	<b>10,313.60</b>	

Тайлант үеийн эзэмшигчийн өмч нь өмнөх оны мөн үеийнхээс 12173.4 сая төгрөгөөр нэмэгдсэн ч, хуримтлагдсан ашиг 1859.8 сая төгрөгөөр буурсан байна.

### 2.4 ЕРДИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО

Ердийн даатгалын компаниуд даатгалын нийт хураамжийн орлогын 11006.5 сая төгрөг буюу 26.3 хувийг давхар даатгалд, 174.5 сая төгрөг буюу 0.5 хувийг хувийг буцаасан даатгалын хураамжид төлж, 30751.6 сая төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлоготой ажилласан байна.

Даатгалын компаниудыг 2013 оны 2 дугаар улиралд олсон даатгалын нийт хураамжийн орлогоор жагсаахад нийт хураамжийн орлогын 30.8 хувь буюу 12932.8 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК бүрдүүлсэн бол “Бодь даатгал” ХХК нийт хураамжийн орлогын 13.8 хувь буюу 5806.2 сая төгрөгийг тус тус бүрдүүлснээр даатгалын хураамжийн орлого нийт зах зээлийн 44.6 хувийг эзэлсэн байна.

Ердийн даатгалын нийт хураамжийн орлого 41.9 тэрбум төгрөг байгаа бөгөөд нийт хураамжийн орлогын 30.8 хувийг “Монгол даатгал” ХХК-ийн орлого эзэлж байна. . [Хүснэгт](#)

	Даатгалын компаниуд	Даатгалын хураамжийн орлого	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	4,056.8	9.7
2	Бодь даатгал ХХК	5,806.2	13.8
3	Ган зам даатгал ХХК	79.7	0.2

4	Мандал женерал даатгал ХХК	2,170.8	5.2
5	МИГ даатгал ХХК	3,759.1	9.0
6	Монгол даатгал ХХК	12,932.8	30.8
7	Гэр даатгал ХХК	246.9	0.6
8	Моннис даатгал ХХК	1,311.8	3.1
9	Мөнх даатгал ХХК	392.6	0.9
10	Номин даатгал ХХК	1,298.3	3.1
11	Практикал даатгал ХХК	1,818.3	4.3
12	Тэнгэр даатгал ХХК	3,246.8	7.7
13	Соёмбо даатгал ХХК	2,789.8	6.7
14	Монре даатгал ХХК	1,138.0	2.7
15	Хаан даатгал ХХК	537.8	1.3
16	УБ хотын даатгал ХХК	346.5	0.8
	<b>ДҮН</b>	<b>41,932.2</b>	<b>100.0</b>

**Даатгалын хураамжийн орлого, компаниудаар**

*сая төгрөгөөр*

**2.5 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР**

2013 оны хагас жилийн байдлаар 11659.9 сая төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 5265.1 сая төгрөгөөр нэмэгдсэн буюу 2.0 дахин өссөн байна.

“Монгол даатгал” ХХК нийт нөхөн төлбөрийн 32.1 хувь, “Ард даатгал” ХХК 10.3 хувь, “Миг даатгал” ХХК 9.5 хувийг тус тус бүрдүүлж нийт зах зээлийн 51.9 хувийг эзэлж байна. Хүснэгт 12

**Даатгалын нөхөн төлбөр**

*сая төгрөгөөр*

	Даатгалын компаниуд	Даатгалын нөхөн төлбөр	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	942.7	8.1
2	Бодь даатгал ХХК	1,197.8	10.3
3	Ган зам даатгал ХХК	23.4	0.2
4	Мандал женерал даатгал ХХК	361.5	3.1
5	МИГ даатгал ХХК	1,105.8	9.5
6	Монгол даатгал ХХК	3,746.6	32.1
7	Гэр даатгал ХХК	63.4	0.5
8	Моннис даатгал ХХК	17.7	0.2
9	Мөнх даатгал ХХК	146.3	1.3
10	Номин даатгал ХХК	495.6	4.3
11	Практикал даатгал ХХК	1,014.2	8.7

12	Тэнгэр даатгал ХХК	931.5	8.0
13	Соёмбо даатгал ХХК	1,099.7	9.4
14	Монре даатгал ХХК	457.5	3.9
15	Хаан даатгал ХХК	22.3	0.2
16	УБ хотын даатгал ХХК	33.9	0.3
	Дүн	11,659.9	100.0

## 2.6 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ОЛГОВРЫН ТҮВШИН

Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй ердийн даатгалын компаниудыг даатгалын нөхөн олговрын түвшингээр харьцуулахад Тайлант үеийн байдлаар “Соёмбо даатгал” ХХК 53.0 хувь, “Монгол даатгал” ХХК 53.0 хувьтай буюу хамгийн өндөр хувьтай байна. Хүснэгт 13

### Нөхөн олговрын түвшин

сая төгрөгөөр

№	Ердийн даатгагчийн нэр	Орлогод тооцсон хураамж	Нөхөн төлбөр	Хувь
1	Ард даатгал ХХК	2,823.1	942.8	33.4
2	Бодь даатгал ХХК	3,510.3	1 197.9	34.1
3	Ган зам даатгал ХХК	257.8	23.4	9.1
4	Мандал генерал даатгал ХХК	1,157.2	361.5	31.2
5	МИГ даатгал ХХК	2,264.7	1 105.8	48.8
6	Монгол даатгал ХХК	7,070.5	3 746.6	53.0
7	Гэр даатгал ХХК	195.9	63.4	32.3
8	Моннис даатгал ХХК	276.4	17.7	6.4
9	Мөнх даатгал ХХК	524.1	146.3	27.9
10	Номин даатгал ХХК	978.9	495.6	50.6
12	Практикал даатгал ХХК	2,289.8	1 014.2	44.3
13	Тэнгэр даатгал ХХК	2,527.9	931.5	36.9
14	Соёмбо даатгал ХХК	2,075.8	1 099.7	53.0
15	Монре даатгал ХХК	909.1	457.5	50.3
16	Хаан даатгал ХХК	104.8	22.3	21.3
17	УБ хотын даатгал ХХК	409.0	33.9	8.3
	<b>ДҮН</b>	<b>27,375.5</b>	<b>11,659.9</b>	<b>42.59</b>

## 2.7 ЕРДИЙН ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА

2013 оны 2 дугаар улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 3536.0 сая төгрөг байна. Тайлант үеийн ашиг алдагдлаар нь жагсаахад “Ард даатгал” ХХК нь 1.8 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, нийт зах зээлийн 52.4 хувийг дангаараа бүрдүүлсэн байна. Тайлант улиралд ердийн даатгалын компаниуд нэгдсэн дүнгээр ашигтай ажилласан байна. Хүснэгт 14

### Цэвэр ашиг, алдагдал



№	Даатгалын компаниуд	/сая төгрөгөөр/	
		Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	Эзлэх хувь
1	Ард даатгал ХХК	1,853.0	52.4
2	Бодь даатгал ХХК	98.3	2.8
3	Ган зам даатгал ХХК	254.7	7.2
4	Мандал женерал даатгал ХХК	103.7	2.9
5	МИГ даатгал ХХК	94.7	2.7
6	Монгол даатгал ХХК	637.3	18.0
7	Гэр даатгал ХХК	50.1	1.4
8	Моннис даатгал ХХК	185.1	5.2
9	Мөнх даатгал ХХК	11.0	0.3
10	Номин даатгал ХХК	42.3	1.2
11	Практикал даатгал ХХК	143.6	4.1
12	Тэнгэр даатгал ХХК	449.3	12.7
13	Соёмбо даатгал ХХК	(89.6)	-2.5
14	Монре даатгал ХХК	41.3	1.2
15	Хаан даатгал ХХК	(413.0)	(11.68)
16	УБ хотын даатгал ХХК	74.2	2.1
	<b>Дүн</b>	<b>3,536.0</b>	<b>100.0</b>

## 2.8 ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН

2013 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сайн дурын болон албан журмын даатгал гэж 2 хуваасан бөгөөд нийт нөөцийн сангийн үлдэгдлийн 27.3 хувийг учирч болзошгүй хохирлын нөөц сан, 57.6 хувийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан, 14.9 хувийг учирсан боловч нэхэмжлээгүй нөөц сангууд эзэлж байна. [Хүснэгт 15](#)

### Нөөцийн сан

сая төгрөгөөр

	Төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Дурын	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан	19,620.4	18,238.1	16,102.1	21,756.3
	Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	6,397.7	3,232.5	3,325.3	6,304.9
Сайн Даатгал	Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	123.7	9,369.3	9,425.7	67.3
	Учирч болзошгүй нөөц сан	11,752.3	2,712.3	907.4	13,557.3
Журмын	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан	8,061.0	7,370.4	6,537.2	8,894.2
	Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан	1,350.7	2,466.3	2,193.8	1,623.1
Албан Даатгал	Нэхэмжилсэн хохирлын нөөц сан	189.4	4,318.0	4,367.7	139.7
	Учирч болзошгүй нөөц сан	959.1	387.9	398.1	948.9

Дүн	48,454.3	48,094.8	43,257.5	53,291.6
-----	----------	----------	----------	----------

## 2.9 ЕРДИЙН ДААТГАЛЫН ДАВХАР ДААТГАЛ

2013 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 11006.5 сая төгрөгийг давхар даатгалд төвлөрүүлсэн байна. “Бодь даатгал” ХХК 15.86 хувь, “Монгол даатгал” ХХК 42.28 хувь тус тус эзэлсэнээр нийт давхар даатгагчид төвлөрүүлсэн хөрөнгийн 58.14 хувийг эзэлж байна. Хүснэгт 16

### Давхар даатгалын хураамж

№	Компанийн нэр	сая төгрөгөөр 2013.06.30	
		тОО	хувь
1	Ард даатгал ХХК	661.9	6.01
2	Бодь даатгал ХХК	1746.1	15.86
3	Тэнгэр даатгал ХХК	747.2	6.79
4	Практикал даатгал ХХК	87.8	0.80
5	Миг даатгал ХХК	1117.2	10.15
6	Монгол даатгал ХХК	4653.6	42.28
7	Номин даатгал ХХК	35.2	0.32
9	Монре даатгал ХХК	54.7	0.50
10	Соёмбо даатгал ХХК	300.6	2.73
11	Ган зам даатгал ХХК		-
12	Мандал женерал даатгал ХХК	560.4	5.09
13	Моннис даатгал ХХК	1041.8	9.47
		<b>11,006.50</b>	<b>100</b>

## 3. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛ

### 3.1 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ХӨРӨНГӨ, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Даатгалын зах зээл дээр “Нэйшнл лайф даатгал” ХХК нь урт хугацааны даатгалын үйл ажиллагааг 2008 оноос хойш явуулж байна. Байгуулагдсан цагаас хойшхи нийт хөрөнгийн хэмжээ 4842.1 сая төгрөгт хүрсэн байна. [График 11](#) /сая төгрөгөөр/



Тус компанийн нийт хөрөнгө сүүлийн 3 жилийн хугацаанд 2.3 дахин нэмэгдсэн байна.

### 3.2 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ОРЛОГО, ДАВХАР ДААТГАЛ, НӨХӨН ТӨЛБӨР

Урт хугацааны даатгалын компани 2013 оны 2 дугаар улирлын байдлаар 483.9 сая төгрөгийн орлоготой ажиллаж, 29.6 сая төгрөгийг давхар даатгагчид төвлөрүүлж, 121.3 сая төгрөгийг нөхөн төлбөрт төлжээ. Сүүлийн 3 жилийн мөн үеийн байдлаар орлого, давхар даатгал, нөхөн төлбөрийн үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулбал: [Хүснэгт 17](#)

Үзүүлэлт	2011.06.30	2012.06.30	2013.06.30
Хураамжийн орлого	142.4	342.9	483.9
Давхар даатгал	40.6	8.5	29.6
Нөхөн төлбөр	21.2	95.2	121.3

*/сая төгрөгөөр/*

### 3.3 УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН АШИГТ АЖИЛЛАГАА, НӨӨЦ САН

Урт хугацааны даатгагч нь 2008 оноос хойш алдагдалтай ажилласаар ирсэн бөгөөд нийт хуримтлагдсан алдагдлын хэмжээ 812.2 сая төгрөгт хүрчээ. Энэ нь нийт эзэмшигчийн өмчийн 21.5 хувийг эзэлж байна. [Хүснэгт 18](#)

Үзүүлэлт	2011.06.30	2012.06.30	2013.06.30
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-	-700.0	-812.2
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	594.4	-53.5	-41.9
Нөөц сан	119.8	428.7	756.3

*/сая төгрөгөөр/*

2010 оноос нөөц сангийн тайланг тайлагнасан байна. [Хүснэгт 19](#)

*/сая төгрөгөөр/*

Даатгалын нөөц	2011-2	2012-2	2013-2
Хувь оролцоотой гэрээний нөөц сан	-	-	-
Хувь оролцоогүй гэрээний нөөц сан	138.1	428.7	756.3
Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан	-	-	-
ДҮН	138.1	428.7	756.3

Нөөц сан 2013 оны 2 дугаар улирлын байдлаар 756.3 сая төгрөг байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 327.6 сая төгрөгөөр буюу 1.7 дахин өссөн байна.

## 4. ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ

### 4.1

### ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ

Тайлант оны 2 дугаар улиралд нийт 17 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж тайлангаа ирүүлсэн байна. Тайлант улиралд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 284,343.2 сая төгрөг болсон ба үүнээс 202.7 сая төгрөгийг даатгалын зуучлалын үйл ажиллагааны орлого эзэлж байна.

Хүснэгт 20

**Даатгалын зуучлагчийн орлого**

*сая төгрөгөөр*

Д/д	Зуучлагч компанийн нэр	2012.06.30	2013.06.30	Өсөлт бууралт
1	“Асимон брокерс” ХХК	33.7	40.9	7.2
2	“АМЕ” ХХК	2.5	10.1	7.6
3	“Ачит ундарга” ХХК	45.6	24.8	-20.8
4	“Лоялти солюшн” ХХК	34.9	16.5	-18.4
5	“Эм Жи Ай Би” ХХК	0	0	0
6	“Ренессанс групп” ХХК	33.8	26.4	-7.4
7	“Жомолхари” ХХК	4.9	0	-4.9
8	“Монголиан интернэшнл брокерс” ХХК	0	0	0
9	“Юу ай би” ХХК	6.7	13.5	6.8
10	“Си эн эн икс” ХХК	0	51.6	51.6
11	“Изи инвестмэнт” ХХК	0		0
12	“Гэрэлт буян ундрах” ХХК	0	3.5	3.5
13	“Нэйшнл эженси” ХХК	44.4	14.3	-30.1
14	"Хасбанк" ХХК			0
15	"Хаан банк" ХХК		1.1	1.1
16	"Хадгаламж банк" ХХК		0	0
17	"Пийс оф лайф" ХХК		0	0
18	"Эрсдлийн шийдэл" ХХК		0	0
19	"SIBS" ХХК		0	0
20	"ASIB" ХХК		0	0
	<b>Нийт дүн</b>	<b>206.5</b>	<b>202.7</b>	<b>-3.8</b>

Тайлант оны хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Асимон брокерс” ХХК 7.6 сая төгрөгөөр, Аме” ХХК 7.6 сая төгрөгөөр, “Юу ай би” ХХК 6.8 сая төгрөгөөр, “Си эн эн икс” ХХК 51.6 сая төгрөгөөр, “Гэрэлт буян ундрах” ХХК 3.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, “Лоялти солюшн” ХХК 18.4 сая төгрөгөөр, “Ачит ундарга” ХХК 20.8 сая төгрөгөөр, “Ренессанс групп” ХХК 7.4 сая төгрөгөөр, “Жомолхари” ХХК 4.9 сая төгрөгөөр, “Нэйшнл эженси” ХХК 30.1 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Бусад компаниуд нь даатгалын зуучлалын орлого төвлөрүүлээгүй байна.

**4.2 ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧ**

Тайлант улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 246.6 сая төгрөг болсон байна. Үүнээс даатгалын хохирол үнэлэгчийн орлого нийт орлогын 54.4 хувь буюу 134.1 сая төгрөг төвлөрүүлж, үлдсэн 45.6 хувийг бусад орлого эзэлж байна. [Хүснэгт 21](#)

**Даатгалын хохирол үнэлгээний орлого**

*сая төгрөгөөр*

Д/д	Үнэлэгч компанийн нэр	2012.06.30	2013.06.30	Өсөлт бууралт
1	“Бест эстимэйт” ХХК	5.7	16.6	10.9
2	“Гэрэгэ эстимэйт” ХХК	32.4	49	16.6
3	“Файн эстимэйт” ХХК	0	0	0
4	“Итгэлт эстимэйт” ХХК	0	22.3	22.3
5	“Мега марз” ХХК	0	5.9	5.9
6	“Вендо” ХХК	10.3	5.7	-4.6
7	Жи ай си си	5.3	16.8	11.5
8	Арвижих эстимэйт ХХК	9.5	9.5	0
9	“Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК	18.3	0.3	-18
10	"Ашид билгүүн" ХХК		8.2	8.2
	<b>Нийт дүн</b>	<b>81.5</b>	<b>134.3</b>	<b>52.8</b>

2012 оны тайлант үеийн хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Бест эстимэйт” ХХК 10.9 сая төгрөгөөр “Гэрэгэ эстимэйт” ХХК 16.6 сая төгрөгөөр “Итгэлт эстимэйт” ХХК 22.3 сая төгрөгөөр “Мега марз” ХХК 5.9 сая төгрөгөөр, “Жи ай си си” ХХК 11.5 сая төгрөгөөр тус тус өсч, бусад хохирол үнэлэгч компаниудын даатгалын хохирол үнэлгээний орлого буурсан байна. Тайлант хугацаанд шинээр “Ашид билгүүн” ХХК нь даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрлийг авсан.

Тайлант хугацаанд “Файн эстимэйт” ХХК даатгалын хохирол үнэлгээний орлогыг төвлөрүүлж ажиллаагүй байна.

## ДҮГНЭЛТ

2013 оны 02 дугаар улирлын байдлаар даатгалын салбарын хөгжлийг өнгөрсөн онуудын мөн үеийн байдалтай харьцуулж үзэхэд даатгалын мэргэжлийн оролцогчийн тоо нэмэгдэх хандлагатай болсон байна. Ялангуяа даатгалын төлөөлөгчийн тоо 3227 хүрч сүүлийн 5 жилээс хойшхи мөн үеийн байдлаас 2.6 дахин нэмэгдсэн нь албан журмын даатгал хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой.

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онуудын мөн үеийнхтэй харьцуулахад 1.1 дахин өсч 113.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнээс ердийн даатгалын компанийн нийт хөрөнгө 108.4 тэрбум төгрөгт хүрсэн нь Хорооны 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар баталсан “Даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой байна.

Мөн даатгалын компаниудын нийт хөрөнгөнд эзлэх эргэлтийн хөрөнгийн хэмжээ 85 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс 2.44 пунктээр өссөн нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд оруулах хэмжээ нэмэгдсэн байна. Даатгагчийн хөрөнгө оруулалт нь зөвхөн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөр байршиж байгаа нь хөрөнгө оруулалтын журамтай холбоотой бөгөөд энэ асуудалд судалгаа хийж, даатгагчийн нөөцийн сангаас хөрөнгө оруулалт хийх журмыг боловсруулан 2013 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 249 дүгээр тогтоолоор батлуулсан.

Тайлант үеийн цэвэр ашиг 3.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 11 хувиар буурсан байна. Энэ нь алдагдалтай ажилласан компаниуд тайлант үеийн ашгийг бууруулахад нөлөөлсөн.

Даатгалын салбарын хэмжээнд тайлант хугацаанд даатгалын компаниудын олсон нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 0.5 тэрбум төгрөгөөр буюу 1.01 дахин нэмэгдэж, мөн даатгалын нөхөн төлбөр 5.2 тэрбум төгрөгөөр буюу 1.8 дахин өссөн нь нөгөө талаас нөхөн олговрын түвшинг нэмэгдүүлэх хандлага ажиглагдлаа. Сүүлийн жилийн дундажаар нөхөн олговрын түвшин 30.0 хувь байсан бол тайлант оны мөн үед 42.0 хувь болсон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалтай холбогдож нэмэгдсэн нь харагдаж байна.

Иймд даатгалын нөхөн олговрын түвшин нэмэгдэж, даатгалын компаниудын цэвэр ашиг өмнөх үеийнхээс буурч байгаа нь цаашид даатгалын салбарыг тэлэх зохицуулалт, хөрөнгө оруулалт болон даатгалын компанийн чадавхийг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулах нь зүйтэй байна.

## ДААТГАЛЫН ГАЗРЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС